

IV

Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс

ҮНДСЭН ХУУЛИЙГ ДЭЭДЛЭН ШҮТЭХ ЁС

О.Мөнхсайхан

*Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн,
хууль зүйн доктор, профессор*

I. Оршил

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Монгол Улсын Ардын багш, гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор Бяраагийн Чимид багш (цаашид “зохиогч” гэх)-ийн *Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс* (УБ, 2006) номын уншлага зохион байгуулж, цаашид уламжлал болгох нь түүний оюуны өвийг түгээж, хойч үедээ дамжуулахын зэрэгцээ 1992 оны ардчилсан Үндсэн хуулийн үзэл баримтлалыг ойлгох, тууштай хэрэгжүүлэх замаар Монгол Улсад Үндсэн хуульт ардчиллыг бэхжүүлэхэд ач холбогдолтой юм.

Зохиогч энэхүү номыг “Үндсэн хуулийн хөгжлийг шинэ хандлагаар судлах нь,” “Шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал бүрэлдэн тогтсон тухай,” “Үндсэн хуулийн үзэл баримтлалын хураангуй,” “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” гэсэн дөрвөн бүлэгтэй бичиж, ихэс дээдэс (төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч) төдийгүй хүн бүрд зориулан Монгол Улсын үндсэн хуульт ёсны агуулгыг хураангуйлан өгүүлжээ. Энэхүү илтгэлд тус номын “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” хэмээх дөрөвдүгээр бүлгийг судална. Энэ хүрээнд Оршил, Дүгнэлтээс гадна II. Монголчуудын түүх ба хууль дээдлэх ёс; III. Үндсэн хуулийг дээдлэн шүтэхийн учир ба нийгэм, сэтгэл зүйн үндэс; IV. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх үзлийг төлөвшүүлэх алхам гэсэн гурван үндсэн бүлэгт багтаан зохиогчийн бичсэн агуулгыг товчилж шинжилнэ.

II. Монголчуудын түүх ба хууль дээдлэх ёс

Зохиогч Монголчуудын төрт ёс, хууль зүйг дээдлэн шүтэх үзлийг хууль дээдлэх ёсны үүднээс гурван их үед ангилжээ.

Нэг дэх үе нь тулгар төрийг байгуулснаас хойш хаант ёсыг шүтэж 720-иод жил үргэлжилсэн байна. Чингис хаан Их Монгол Улсаа 1206 онд даяар олноо тунхаглан, улсыг байгуулснаараа түүхэн ач холбогдолтой билээ. Энэ үед хууль дагаж шийтгүүлэх ёс нэвтэрсэн ч энэ нь "...орчин цагийн хууль дээдлэх ёс (Rule of Law) зарчмын агуулгатай яг адилгүй, харин "хуулийн аргаар дарангуйлах ёс"-ыг бататгасан шинжтэй" байсан.¹ Тодруулбал, Чингис хааны зарлигуудыг нэгтгэсэн Их засаг хуулийг эзэнт гүрэнд дагаж мөрдөж байсан ч энэ нь хааны хэмжээгүй эрхийг хязгаарлахад чиглэгдээгүй учраас хууль дээдлэх ёс биш байв. Өөрөөр хэлбэл, Энэ үеийн эрх зүйн тогтолцооны мөн чанарыг "эрхийн тухай үзэл санаа төдийлөн хөгжөөгүй, эрх зүйн зохицуулалтын механизм нь ч эрхийг хамгаалахаасаа илүү төр, түүний эрх мэдэл, тогтсон ёс заншил, суртлыг хамгаалахад чиглэгдсэн байлаа."² Хууль дээдлэх ёсны үүднээс харвал Монголын эзэнт гүрэн бутран унасны дараа болон Монголчууд Манж чин улсын эрхшээлд байх үед хууль зүйд дорвитой өөрчлөлт ороогүй.

Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн тунхагласны дараа (1911-1924) үндсэн хуульт ёсны үзэл санаа нэвтэрчээ. Богд хаант Монгол Улсад хэмжээгүй эрхт хаант засаг байсан боловч яам, хаанд зөвлөх хурал зэргийг байгуулж орчин үеийн төрийн тогтолцоог бүрдүүлж эхэлсэн байна. Үүний зэрэгцээ Европ, Ази, Америк тив дэх олон орны үндсэн хуулийг харьцуулан судалж, хүний халдашгүй эрх, эрх чөлөөг хамгаалах, парламентыг байгуулах, хаан, засгийн газар, парламентын хооронд төрийн эрх мэдлийг хуваарилах зэрэг саналыг хэлэлцэж Үндсэн хуулийн

¹ Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил) (УБ, 2006), 124.

² Н.Лүндэндорж, Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага (УБ, 2002), 188.

төслийн хэд хэдэн хувилбарыг хүртэл боловсруулаад байжээ.³ Үүний зэрэгцээ 1921 онд Ардын хувьсгал ялсны дараа 1924 он хүртэл ардын эрхтэй хэмжээт цаазат засгийг тогтоон хэрэгжүүлж байсан зурвас үе бий.⁴

Хоёр дахь үед 1924-1990 оны социалист дэглэм хэрэгжсэн хугацааг хамааруулжээ. Энэ үед “нам засаг” нэрийн доор улс төрийн дээд удирдагчдыг шүтэн биширч, үг сургаалыг нь дагаж нэгэн жарныг илээсэн гэж зохиогч дүгнэжээ. “Энэ үед төрийн дээр нам, намын дээр удирдагч, хуулийн дээр намын шийдвэр оршиж, ард түмнийг дагуулж байлаа.”⁵

Зөвлөлт Орос, Коминтерны шахалтаар Монголчууд өөрсдийн судалж боловсруулсан Үндсэн хуулийн төслөөс татгалзаж 1924 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улс (цаашид “БНМАУ” гэх)-ын Үндсэн хуулийг баталсан. Энэ гол хууль нь социалист чиг баримжаатай ч түүхэн баримт бичиг юм. Нэгд, 1924 оны Үндсэн хууль бол манай анхны бичмэл Үндсэн хууль. Яагаад гэвэл, энэ нь суурь харилцааг зохицуулсан хэм хэмжээг төрөлжүүлж, системтэйгээр нэг баримт бичигт тусгасан гэдэг утгаараа бичмэл Үндсэн хууль юм. Үүнээс өмнө Тангаргийн гэрээ (1921), Нутгийн захиргааны дүрэм (1923) зэрэг Үндсэн хуулийн шинжтэй актуудыг батлан хэрэгжүүлж байсан ч эдгээр нь онолын хувьд бичмэл Үндсэн хуульд тооцогдохгүй юм. Эдгээр актыг Засгийн газраас баталсан бол 1924 оны Үндсэн хуулийг Улсын анхдугаар Их хурлаас баталсан. Хоёрт, 1924 оны Үндсэн хууль нь хаант ёсыг халж, Бүгд найрамдах ёсыг тогтоосон. Учир нь, тус Үндсэн хуулийн оршилд “Харьяат улсад Бүгд Найрамдах Ардын Засгийг” явуулахаар тогтсон гэжээ. Гуравт, энэ суурь хууль нь ерөнхийлөгчийн засгаас татгалзаж, социалист маягийн нэг намт,

³ Жишээлбэл, Ерөнхий сайд Д.Бодоо, эрдэмтэн Ж.Цэвээн нар тус тусдаа Үндсэн хуулийн төсөл боловсруулж, Монгол Улс хэмжээт эрхт хаант засагтай байхаар тусгасан байв.

⁴ Ц.Батбаяр, Д.Лүндээжанцан, Хэмжээт цаазатаас Бүгд найрамдах засагт шилжсэн нь: Анхдугаар Үндсэн хууль (1921-1924) (УБ, 2023).

⁵ Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (УБ, 2006), 123.

жинхэнэ ардын ашиг сонирхлыг төлөөлөх хурал бүхий засгийн хэлбэрийг сонгосон юм. Тус Үндсэн хуулийн оршилд "... да жунтан гэдэг ерөнхий даргыг сонгохгүй улсын бүх дээд эрхийг Улсын Их Хуралд ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраа хадгалах"-аар тогтсоныг дурдаад Хоёрдугаар зүйлд нь "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зорилт бол хуучны эзэрхэг харгисын ёс суртлын үлдэгдлийг үндсээр устгаж, улс төрийн захиргааны явдлыг жинхэнэ ардын ёсонд нийлүүлж, шинэ ёсны Бүгд Найрамдах Улсын үндэс тулгуурыг бататган бэхжүүлнэ" гэжээ. Дөрөвт, 1924 оны Үндсэн хууль бол геополитикийн хэцүү нөхцөлд улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хууль зүйн хувьд баталгаажуулсан. Жишээлбэл, Орос, Хятад (тухайн үеийн ЗСБНХУ болон БНХУ) 1924 оны 5 дугаар сард Бээжингийн гэрээг байгуулж, түүндээ "ЗСБНХУ нь Гадаад Монголыг Дундад улсын бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрч, Хятадын бүрэн эрхийг хүндэтгэнэ" гэж заажээ. Манай тухайн үеийн удирдагчид улсын тусгаар тогтнолын эсрэг энэ мэт алхмыг эрс эсэргүүцэж, үүнийхээ дээд илэрхийлэл болгон анхдугаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд "Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард Улс хэмээж..." Бүгд найрамдах төдийгүй тусгаар тогтносон, бүрэн эрхт улс гэдгээ зарлан тунхагласан юм.

Зөвлөлт Холбоот Улсад гарсан өөрчлөлт БНМАУ-ын Үндсэн хуулийг 1940, 1960 онд тус тус шинэчлэн найруулахад нөлөөлсөн⁶ бөгөөд эдгээрийн хооронд 1949 онд Үндсэн хуулийг мөн шинээр баталсан гэх судалгаа бий.⁷ БНМАУ-ын бүх Үндсэн хуулийн нийтлэг тал нь Монгол Ардын Хувьсгалт Нам марксист-ленинист онолыг удирдлага болгон "төр, нийгмийг удирдан чиглүүлэгч хүч" байх, Сайд нарын зөвлөлийн загвар (дараа нь төрийн зөвлөлийн загвар) хэрэгжүүлж байсан ч цаанаа намын болон засгийн удирдлагыг

⁶ George Ginsburgs, Mongolia's "Socialist" Constitution, Pacific Affairs, Summer, 1961, Vol. 34, No. 2 (Summer, 1961), 142; George Brunner, "The Functions of Communist Constitutions, an Analysis of Recent Constitutional Developments," Sijthoff & Noordhoff (1977), 121.

⁷ Б.Баярсайхан, Монгол Улсын Үндсэн хуульг ёсны уламжлал (УБ, 2017).

нэг хүнд төвлөрүүлж, дарангуйлал үүсэх нөхцөлийг бүрдүүлжээ. Социалист Үндсэн хууль нь төрийн эрх мэдлийг хуваарилах (хязгаарлах) бус, харин төвлөрүүлэх; хувь хүн бүрийг хүн гэж хүлээн зөвшөөрөх бус, нийгмийн нэг бүрэлдэхүүн гэж нэгтгэх; нийгмийн амьдралын гол хүрээнд баримтлах үнэт зүйлийг тулгаж байв.⁸ Эрх, үүрэг нэгдэлтэй байх социалист ойлголтоор үндсэн эрхийн зэрэгцээ олон үүрэг хүлээлгэж, хувь хүний субъектив эрхийг хэрэг дээрээ үгүйсгэж байв. Иймээс, өмнөх дэглэмийн үед тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэхжүүлсэн (олон улсаар хүлээн зөвшөөрүүлсэн, 1961 онд НҮБ-ын гишүүн болсон зэрэг)-ий зэрэгцээ иргэдийн эдийн засаг, нийгмийн эрхийг хангаж, олон талаар дэвшин хөгжсөн боловч иргэний болон улс төрийн эрхийг хамгаалах бие даасан шүүх эсхүл бусад механизм үгүй байсан учраас эдгээр эрхийг тунхаг төдий байлгаж, өргөнөөр хязгаарлаж, заримдаа ноцтой зөрчиж байв. Жишээлбэл, гаднын шахалтаар их хэлмэгдүүлэлт гэгдэх геноцид 1937-1939 онд үйлдэгдсэн.

Гурав дахь үед өнөөгийн Монгол Улс нь Их Монгол Улсынхаа голомтыг сахиж, тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс байхын зэрэгцээ өөрийн төрт ёсны түүх дэх анхны ардчилсан Үндсэн хуулийг 1992 онд батлан гаргаж хууль дээдлэх ёсонд шилжсэн байна. 1992 оны Үндсэн хууль нь 32 жил мөрдөгдөж, манай түүхэнд хамгийн удаан үйлчилж буй Үндсэн хууль болж байна. Үндсэн хууль тогтоогчид Үндсэн хууль батлахдаа эрх зүйт төрийг байгуулж буй гэж ойлгож, энэ санаагаа “хууль дээдлэх ёс” гэсэн хэллэгээр Үндсэн хуулийн §1.2-т илэрхийлсэн. Зохиогч “Монгол дахь хууль дээдлэх ёсны үзэл санаа нь сая дээр дурдсан “Rule of law” буюу “эрх зүйт ёс”-ны, “Rechtsstaat” буюу “эрх зүйт төрийн” нэгэн хувилбар гэж болно. Эдгээр нь аялгуу ялгаатай ч агуулга, мөн чанараараа адил санаа”⁹ гэж бичжээ. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд “хууль дээдлэх зарчмыг тунхагласан нь

⁸ George Brunner, “The Functions of Communist Constitutions, an Analysis of Recent Constitutional Developments,” 143-144.

⁹ Мөн энд, 67; Б.Чимид, “Хууль дээдлэх ёсыг хангахад шударга шүүхийн үүрэг” (2009), 5.

эрх зүйт төрийн чиг баримтлалыг илэрхийлэх” утгатай.¹⁰ Иймд Үндсэн хуульд байхгүй элдэв нэр томьёог зохиохын оронд “хууль дээдлэх ёс” гэсэн нэр томьёог хэрэглэж хэвших нь зүйтэй боловч the Rule of Law, Rechtsstaat хоёрыг ялгаж бичих шаардлагатай бол эхнийхийг нь хууль дээдлэх ёс, удаахыг нь эрх зүйт төр гэдгээр буулгаж болох юм.

Түүхэн үүслийн хувьд хууль дээдлэх ёс нь хууль бүхнийг засаглах, ялангуяа засаг төрийг Үндсэн хуулийн болон бусад хуулийн хязгаарлалтад оруулах зорилготой гэжээ.¹¹ Зохиогчийн тодорхойлсон энэ зорилго нь хэн бүхэн хуульд захирагдах, төрийн эрх мэдлийг хуулиар хязгаарлах гэсэн хууль дээдлэх ёсны түгээмэл утгатай дүйж байна. Дараах гол шинж бүрдсэн байвал хууль дээдлэх ёс (эрх зүйт төр) хэрэгжиж байгаа гэж нарийвчилсан шалгуурыг нь тодорхойлжээ (уг номын өөр өөр талд оруулсан жагсаалтыг нэгтгэв):¹²

1. Хүний эрхийг баталгаатай хангах;
2. Эрх мэдэл хуваарилах;
3. Хүний эрх, эрх чөлөө нь хараат бус, шударга, алагчлалгүй шүүхээр хамгаалагдсан байх;
4. Парламент нь Үндсэн хуулиа, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага нь Үндсэн хууль ба бусад хуулийг гуйвалтгүй биелүүлэх, зөв хэрэглэх;
5. Хууль нь итгэхүйц бөгөөд тийм итгэл олсон байх;
6. Эрх зүйн хэм хэмжээгээр тохируулбал зохих алив харилцааг элдэв дэд акт, заавраар биш, хуулиар буюу хууль тогтоомжийн актаар зохицуулах;
7. Аливаа хууль нь Үндсэн хуульд, эрх зүйн бусад (дэд) бүх акт нь хуульд нийцсэн буюу захирагдмал байх;

¹⁰ Мөн энд, 67.

¹¹ Мөн энд, 67; 124.

¹² Мөн энд, 67; 125-126.

8. Үндсэн хууль болон түүнд нийцсэн хууль тогтоомжийн аливаа актыг Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр хүчин төгөлдөр дагаж мөрдөх;
9. Хууль зөрчсөн гэм буруутай хэн боловч ...хууль зүйн зохих хариуцлага хүлээх;
10. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглосон байх;
11. Үндсэн хууль зөрчсөнийг нотолсон Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, ердийн хууль зөрчсөнийг тогтоосон бусад шүүхийн шийдвэр хүчин төгөлдөрт тооцсон өдрөөс эхлэн холбогдох бүх этгээдэд заавал биелүүлэх хүчинтэй байх, хууль зүйн үндэслэлтэй бол түүнийг албадан биелүүлэх;
12. Шударга ёс, зүй ёсны хийгээд нийгмийн бусад хэм хэмжээ Үндсэн хуулийн хүрээнд багтсан байх зэрэг.

Эндээс үзвэл зохиогч хууль дээдлэх ёсыг агуулгын үзэл баримтлалаар тайлбарласан байх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (цаашид “Үндсэн хуулийн цэц” гэх) энэ зарчмыг Улсын Их Хурал (цаашид “УИХ” гэх)-аас баталсан хуулийг дагаж мөрдөхөөс илүү өргөн утгатай гэж тайлбарлаж ирсэн.¹³

Хууль дээдлэх ёсны тухай агуулгын үзэл баримтлал нь хууль тодорхой байх, буцаан хэрэглэхгүй байх зэрэг хэлбэрийн зарчим төдийгүй хувь хүний үндсэн эрхийг хамгаалах гэсэн агуулгын зарчмыг багтаадаг.¹⁴ Энэ үзэл баримтлал нь либерал үндсэн хуульт ёс бүхий нөхцөлд зайлшгүй. Үндсэн хууль нь үндсэн эрхийг хамгаалж, төрийн эрх мэдлийг хуваарилж, хяналт тэнцлийг хангах замаар төрийн эрх мэдлийг бодитойгоор хязгаарлах, ард түмний эрх мэдлийг хэрэгжүүлж баталсан дээд хууль буюу Үндсэн хуульд ердийн хууль, эрх зүйн бүх акт бүрнээ нийцэх, ийнхүү

¹³ Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №4, 1998.04.27; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №8, 2007.06.20; Үндсэн хуулийн цэц, Тогтоол №3, 2007.12.12; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №5, 2006.05.31; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №6, 2007.05.23; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт №6, 2017.10.25; Үндсэн хуулийн цэц, Дүгнэлт 07, 2017.11.29; Үндсэн хуулийн цэц, Тогтоол 02, 2017.12.20; Үндсэн хуулийн цэц, Тогтоол 01, 2018.01.17.

¹⁴ Дэлгэрэнгүй: О.Мөнхсайхан, Үндсэн хуулийн хяналт ба тайлбар: үндсэн эрх (УБ, 2022), 9-40.

нийцсэн эсэхийг шүүхийн журмаар хянан шийдвэрлэхийг Үндсэн хуульт ёс шаарддаг.¹⁵ Хууль дээдлэх ёсны тухай агуулгын үзэл баримтлал болон үндсэн хуульт ёс нь дэлхий нийтийн түгээмэл зарчим болж хүлээн зөвшөөрөгдсөн.

III. Үндсэн хуулийг дээдлэн шүтэхийн учир ба нийгэм, сэтгэл зүйн үндэс

Зохиогч “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх нь хууль дээдлэх ёсны суурь” гээд ийнхүү тооцоход хоёр төрлийн шалтгаан байгааг тайлбарлажээ. Нэгдүгээр шалтгаан нь (1) “өмч, аж ахуйн олон янзын төрөл хэлбэр, хэвшил өөр өөрийн сонирхол бүхий бүлэг давхраанд суурилсан,” (2) “ардчилсан дэглэмтэй, олон намт”, (3) “нийгмийг засаг төр, иргэний нийгэм гэж хуваан үзэх болсон,” (4) “иргэний нийгмээ захиргааддаг тогтолцооноос түүнд үйлчилдэг болсон,” (5) “ургалч үзлийг” хүлээн зөвшөөрсөн зэрэг Монголын нийгмийн улс төр, эдийн засаг, нийгэмшил, соёл оюуны үндэс шинэчлэгдсэнээс үүдэлтэй.¹⁶

Үндсэн хуулийг дээдлэн шүтэхийг зайлшгүйд хүргэсэн хоёр дахь шалтгаан нь Үндсэн хуулийн гүйцэтгэх чиг үүрэг эрс өөрчлөгдөж, өсөн нэмэгдсэн явдал гэжээ. Тодруулбал, Үндсэн хууль нь нийгмийн (1) улс төрийн харилцааны үндсийг тогтоох, (2) эдийн засгийн харилцааны үндсийг бэхжүүлж хамгаалах, (3) нийгэмшлийн, (4) хууль зүйн төдийгүй (5) ард түмний туйлын хүслэн (ideal)-г тодорхойлох чиг үүрэгтэй гээд тус бүрийг нь Үндсэн хуулийн холбогдох заалтаас эшилж тайлбарласан байна.¹⁷ Эдгээрээс ард түмний туйлын хүслэнг тодорхойлох чиг үүргийг нь энэ илтгэлийн хүрээнд авч үзье.

Үндсэн хуульт ардчилсан нийгэмд хүмүүс, нийгэмшлийн бүлгүүд өөрсдийн итгэл үнэмшилтэй байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэхийг хүлээн зөвшөөрдөг учраас улс төрийн плюрализм

¹⁵ Үндсэн хуулийн цэц, Тогтоол 02, 2024.11.08.

¹⁶ Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (УБ, 2006), 128.

¹⁷ Мөн энд, 128-34.

буюу ургалч үзэл нь уг нийгмийн салшгүй шинж ажээ. Тодруулбал, “...өдгөө өөр өөрийн үзэл бодолтой, (либераль, радикал, консерватив баруун, зүүн, социалист, коммунист, төв үзэл гэх мэт) улс төрийн өвөрмөц сонирхол бүхий олон нам байгаа учир ганц нам ард түмнийг бүхэлд нь төлөөлөн хүн амыг нийтэд нь алсын алсад дагуулах боломжгүй юм. Түүнчлэн хүн бүр шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй, өөр өөр шашин оршин буй учир нэг нь бүгдийг дагуулах чадваргүй.”¹⁸ “Гэвч иргэний нийгмийг бүрдүүлж буй бүх ард түмнийг нэгтгэж нэгэн бүхэл болохуйц оюун санаа, хүсэл зориг, ашиг сонирхлын хүчин зүйл байхгүй бол тэр ард түмэн зүг бүр зүтгэсэн хэсэг бусад бүлэглэл болон хувирах магадлал бий”¹⁹ гэж зохиогч бичжээ. Ийм хүчин зүйл нь тухайн ард түмний туйлын хүслэн (эрхэм зорилго тэмүүлэл) бөгөөд түүнийг гагцхүү “Үндсэн хуулиар томъёолж, дагуулахаас өөр арга зам одоогоор нээгдээгүй” хэмээжээ.²⁰

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд манай ард түмний туйлын хүслэнг дараах томъёоллоор илэрхийлэн бататгасан гэж зохиогч үзсэн байна:

Монголын ард түмэн бид:

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
- хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
- хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.

¹⁸ Мөн энд, 132.

¹⁹ Мөн энд, 131.

²⁰ Мөн энд, 132.

Ард түмний нэрийн доор тунхагласан эдгээр үндэслэл өөр өөрийн өргөн агуулга, гүн утга бүхий дээд эрмэлзэл тул тус тусдаа нухацтай тайлбар шаардана гэжээ.

Үндсэн хуулийн оршилд зарлан тунхагласан “иргэний нийгэм”-ийг “амьдралын гүнд байсаар ирсэн төр, нийгмийн зөв оршихуйн үндэс” гэдэг талаас нь цухас тодорхойлжээ: “Иргэний нийгэм нь засаг төрийн байгууллагын эх үүсвэр байж, үйл ажиллагаанд хяналт тавьж, түүнийг өөрсдөдөө үйлчилдэг “зарц” болгож чадсан тийм ардчилсан цогц тогтолцоо болгон төлөвшүүлж, бэхжүүлэхийг л “цогцлуулан хөгжүүлэх” гэсэн нэр томъёогоор ард түмэн эрхэм зорилгоо болгожээ...”²¹ Иймээс, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл нь дараах байдлаар иргэний нийгэмд хүчин зүтгэх үүрэгтэй ажээ:

- Парламент (гишүүд) нь ард түмнээс бүрэн эрх (мандат) авч гаргаад тэднийг эргэн захирч давамгайлж байх бус, харин төрийн мэргэшсэн аппаратын болзошгүй дарамтаас нийт иргэний нийтлэг ашиг сонирхлыг хууль журамд тусган хамгаалж хянаж байх;

- Гүйцэтгэх (захиргааны) төв, орон нутаг, салбар хүрээний байгууллага, аппарат нь хуулийг биелүүлэн, төрөөс үзүүлэх нийтийн үйлчилгээ, нийгмийн (халамж, хангамж) хамгааллыг зохих ёсоор зохион байгуулж хүн амд үйлчлэх;

- Шүүх эрх мэдлийн байгууллагууд нь шударга ёс, эрх зүйн үндсэн дээр гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг засаг төрийн дур зоргын ажиллагаа, “хуульд дуулгаваргүй этгээд”-ийн хандлагаас хамгаалах...²²

²¹ Мөн энд, 133.

²² Мөн энд, 133-134.

Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч хэн боловч "... "би хүмүүсийг захирч байна" гэж ойлгож ихэмсэг, дээрэлхүү, "цэвдэг хүйтэн" хандах биш, харин "тэдэнд үйлчилж, тусалж байна" гэж өгөөмөр сэтгэж дадахыг, өөрөөр хэлбэл урьдын захиргаадалтын арга барилаа үндсээр нь эргүүлэн энэрэнгүйжүүлэх буюу хүмүүнлэгжүүлэх нь төрийн албаны ёс зүй нийгмийн сэтгэл зүйн шинэтгэл болох ёстой" гэжээ.²³ Эндээс харвал хүмүүнлэг гэдэг нь хүнийг хүн гэдгээр хүлээн зөвшөөрч хүн гэж хүндэтгэх утгатай байна. Иймд Үндсэн хуулийн оршилд зарлан тунхагласан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх гэдэг бол Монгол Улсад хүн бүрийг хүн гэж хүлээн зөвшөөрч, хүний ёсоор хүндэтгэх (хүний нэр төр буюу "human dignity"-ийг хүндэтгэх) болон үндсэн эрхийг нь баталгаатай эдлүүлэхийг төрд үүрэгжүүлсэн, улмаар төрийн эрх мэдэл иргэдээс эх үүсвэртэй байж, иргэдийн хяналт дор хэрэгжиж, иргэдэд үйлчилдэг, ардчилсан дэглэм бүхий цогц тогтолцоог төлөвшүүлж бэхжүүлэх эрхэм зорилго юм.

Ардчилсан нийгэмд ургалч үзэл байх ч Үндсэн хуулиар үндэсний эв нэгдэл нь хангагдана. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн гол агуулга (төрийн эрх мэдлийн бүтэц, улс төрийн процессыг тодорхойлсон суурь зарчим болон үндсэн эрх, эрх чөлөө) дээр нэгдэх боломжтой. Ардчилсан нийгэмд улс төрийн, шашны, ёс суртахууны эсхүл философийн үндэслэл бүхий, иж бүрэн номлолууд (reasonable comprehensive doctrines) зэрэгцэн орших нь түүний улс төрийн соёлд түр зуур илрэх шинж бус, харин байнгын салшгүй шинж гэж Жон Роулс бичсэн. Энэ фактыг "үндэслэл бүхий ургалч үзэл" (reasonable pluralism) гэх бөгөөд дарангуйлж хүчирхийлэхгүйгээр аль нэг номлолд бүх хүнийг нэгтгэх боломжгүй.²⁴ Ардчилсан нийгэмд иргэд нь үндэслэл бүхий өөр өөр номлолыг баримтлах боловч тэдгээр номлолын

²³ Мөн энд, 134.

²⁴ John Rawls, *Justice as Fairness: A Restatement*, ed. Erin Kelly (Belknap Press, 2001), 33–34.

үндэслэлтэй байдал нь зүй ёсны зарчмууд, үүний дотроос эн тэргүүнд Үндсэн хуулийн гол агуулга дээр давхцаж зөвшилцөл (overlapping consensus)-д хүрч, Үндсэн хуульд ардчилсан дэглэм тогтвортой хэрэгжих боломжтой.²⁵ Ардчилсан Үндсэн хуулийн оршилд дэвшүүлсэн эрхэм зорилго болон Үндсэн хуулийн зүйл, заалт бүрийг тайлбарлахдаа тухайн Үндсэн хуулийн гол агуулгад нийцүүлбэл зохино.

Зохиогч 1992 оны Үндсэн хууль бол төрийн (ордны) эргэлтийн аргаар гэнэт батлагдаагүй бөгөөд “нэг үзэл суртал” нэрийн дор Зөвлөлт маягийг даган дуурайсан (түүнд захирагдсан) өмнөх Үндсэн хуулиас ялгаатай гэжээ. Үндсэн хууль бол “ард түмний сонголт, хамтын бүтээл” гэдгийг түүнийг боловсруулж баталсан үйл явцыг тоймлон харуулж, энэхүү “төрөлх” чанараараа “Монгол Улсын Үндсэн хууль бол манай ард түмний нийтээрээ дээдлэн шүтэж, ёсчлон сахих нийгэм, сэтгэл зүйн гүн үндэстэй” бөгөөд “түүнийг үеэс үед залгамжлан дээдэлж хэвшүүлбээс нэгэн зүйл үндэсний бахархал болно” гэжээ.²⁶ Энэ санааг дэлгэрүүлбэл Үндсэн хуулийг хэлэлцэж баталсан процедур болон гол агуулга нь түүнийг дээдлэн шүтэх нийгэм, сэтгэл зүйн үндэслэл болно гэж ойлгож болно.

Процедур. Үндсэн хуулийн төслийг баталсан процедур нь Монголын ард түмний бүрэн эрхт байдлыг хангаж, өөрсдөө үндэслэлтэйгээр хийсэн сонголт буюу хамтын бүтээл байх нөхцөлийг хангасан учраас энэ түүх нь өөрөө бахархал, хүндэтгэл төрүүлдэг билээ. 1990 онд тайван замаар хийсэн ардчилсан хувьсгалын үр дүнд анхны ардчилсан сонгуулиар байгуулагдсан Ардын Их Хурал, Улсын Бага Хурал Үндсэн хуулийн төслийг нэг жил хагас орчим хугацаанд боловсруулж хэлэлцэж баталсан. Анхны Ерөнхийлөгчөөр ахлуулж, төрийн болон олон намын төлөөлөл,

²⁵ Дэлгэрэнгүйг дараах номоос уншина уу: John Rawls, Political Liberalism, Expanded edition (Columbia University Press, 2005).

²⁶ Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (УБ, 2006), 139.

хуульч, эрдэмтдээс бүрдсэн “Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комисс” Үндсэн хуулийн төслийг анхлан боловсруулсан. Уг төслийг Улсын Бага Хурлаар 1991 оны хавар хэлэлцэж, дараа нь олон нийтэд танилцуулсан бөгөөд давхардсан тоогоор 900 гаруй мянган хүний саналыг авсан гэдэг. Мөн төслийг англи хэл рүү орчуулж, гадаадын экспертүүдийн санаа бодлыг сонссон, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулсан байна. Ийнхүү чамбайруулсан төслийг Улсын Бага Хурал 1991 оны намар дахин хэлэлцсэн, улмаар Ардын Их Хурал заалт бүрээр нухацтай хэлэлцэж баталсан. Энэ явцад Монгол Улс засгийн хэлбэрийн хувьд парламентын бүгд найрамдах улс байх, Үндсэн хуулийн хяналтыг Үндсэн хуулийн шүүх (Үндсэн хуулийн цэц)-д харьяалуулах зэрэг суурь асуудал бүрийг тухайн үед цугларсан мэдээллийн хүрээнд гарч болох хамгийн сайн үндэслэлүүдийг ил тодоор ярилцсаны үндсэн дээр зөвшилцөж шийдвэрлэж байсан нь хуралдааны тэмдэглэлээс харагддаг. Иймээс, 1992 оны Үндсэн хууль нь улс төрийн гол намууд болон иргэдийн дунд өргөнөөр хүлээн зөвшөөрөгддөг, легитим чанар сайтай.

Гол агуулга. 1992 оны Үндсэн хууль нь агуулга талаасаа Монголын түүхэн дэх анхны ардчилсан Үндсэн хууль учраас түүнийг дээдлэн шүтэх үндэслэл болдог. Үндсэн хуулийг хэр сайн бэ гэдгийг олон шалгуураар хэмжиж болно. 1791 оны Францын Хүний болон иргэний эрхийн тунхгийн 16 дугаар зүйлд “Эрхийг баталгаажуулаагүй эсхүл төрийн эрх мэдлийг хуваарилаагүй нийгэмд Үндсэн хууль байхгүй” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хууль энд дурдагдсан ардчилсан үндсэн хуулийн хоёр шалгуурыг бүрэн хангадаг.²⁷

²⁷ Үндсэн хуулийн цэц, Тогтоол 02, 2024.11.08.

1992 оны Үндсэн хууль бол Монголын төрт ёсны түүхэнд анх удаа хүн бүрийг хүн гэж хүлээн зөвшөөрч, хүн хувьдаа эдлэх наад захын үндсэн эрхийг цогцоор нь бүрэн тусгасан. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиар хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байх, үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх зэрэг иргэний болон улс төрийн эрх (I үеийн эрх), төдийгүй эд мөнгөний тусламж авах эрх, сурч боловсрох эрх зэрэг эдийн засаг, нийгэм, соёлын эрх (II үеийн эрх)-ийг өргөн хүрээнд хамгаалсан бөгөөд “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх” (III үеийн эрх)-ийг ч баталгаажуулсан. Түүнчлэн, Үндсэн хуулийн §10.2-т заасны дагуу хүн бүр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан эрхийг баталгаатай эдэлнэ.

1992 оны Үндсэн хууль нь ард түмнээс шууд сонгогддог Ерөнхийлөгч бүхий парламентын тогтолцоог сонгож, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хуваарилаад зогсохгүй эдгээр эрх мэдлийн салааны хоорондын харилцан хяналт, тэнцлийг суулгаж өгсөн. Тодруулбал, хууль тогтоох эрх мэдлийг УИХ-д хадгалуулдаг (Үндсэн хууль, §20, §25.1.1) бол УИХ-ын баталсан хуулийн биелэлтийг Засгийн газар, түүний харьяа байгууллагууд хангаж ажилладаг (Үндсэн хууль, §38) бөгөөд шууд сонгогддог Ерөнхийлөгч нь бодлого тодорхойлохгүй, гүйцэтгэх эрх мэдлийг тэргүүлэхгүй, харин хяналт (check) тавих шинжтэй бэлгэдлийн болон арбитражийн чиг үүрэгтэй.²⁸ Харин, Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг Цэц, хуулийг зөрчсөн эсэхийг шүүх хянаж шийдвэрлэнэ (Үндсэн хууль, §47.1, §64). Төрийн эрх мэдлийн эдгээр байгууллага нь Үндсэн хууль, хууль зөрчсөн эсэх эсхүл бодлогын хувьд алдаа гаргасан эсэхийг харилцан хянадаг бөгөөд энэ нь дур зоргоор авирлах, иргэний үндсэн эрхийг зөрчихөөс сэргийлэх зориулалттай механизм юм.

²⁸ О.Мөнхсайхан, Ерөнхийлөгч: эрх зүйн байдал, бүрэн эрх (УБ, 2022).

IV. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх үзлийг төлөвшүүлэх алхам

Хууль дээдлэх үзэл эцсийн дүнд эрх зүйн ухамсар, түүгээр дэмжигдсэн ёс суртахууны үнэлэмж мөн гэвэл ойлгоход дөхөм гэжээ. Тодруулбал, хууль дээдлэх ёс гэдэг нь “элдэв актыг үл оролцуулан зөвхөн хуулийг эрх зүйн болон нийгмийн бусад хэм хэмжээнээс дээгүүрт тавьж ухамсарласан дотоод итгэлийн үндсэн дээр нийтээр, юуны өмнө засаг төр өөрөө сахин биелүүлэх, хэрэглэх, хамгаалах ёсыг хэлж, ойлгож байна” гэжээ.²⁹ Ийм эрх зүйн ухамсар, түүний илрэл болсон соёлын ач холбогдлыг зохиогч тодотгосон байна.

Үндсэн хууль батлах төдийгөөр хууль дээдлэх ёсыг соёл болгон нутагшуулах боломжгүй. Хууль дээдлэх ёс хэрэгжихэд тодорхой эрх зүйн ухамсар, соёлыг төлөвшүүлэх шаардлагатай. Энэ талаар Зиммерман хэлэхдээ:

Энэ соёл нь жирийн иргэн болон нийтийн албан тушаалтан хууль дээдлэх ёсны суурь зарчим, институтэд чин үнэнч байх нийгэм - улс төрийн контекстээр илрэх хууль зүйн хэм хэмжээнд хандах эерэг хандлагыг агуулдаг. Эдгээр институтүүд болон суурь зарчмыг сахин биелүүлэх, сахин биелүүлэхийг шаардах, сахин биелүүлээгүй этгээдийг шүүмжлэх, сахин биелүүлээгүйг засахад зайлшгүй аливаа арга хэмжээг авах замаар тэд үнэнч байдлаа илтгэн харуулдаг.³⁰

Хууль дээдлэх соёл сул төлөвшсөн байдаг нь шилжилтийн улсын гол сорилт юм. Учир нь, эдгээр улсын иргэд болон нийтийн албан хаагчид дийлэнхдээ хууль дээдлэх ёсны институт, зарчмыг хүндэлж хэвшээгүй байдаг. Гэвч, тухайн цаг үеийн энэ

²⁹ Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (УБ, 2006), 67, 125-126.

³⁰ Zimmermann, “Rule of Law as a Culture of Legality,” 24.

нөхцөл нь хууль дээдлэх соёлыг төлөвшүүлэх боломжгүй гэсэн үг биш. Аливаа нийгэмд хууль дээдлэх ёсыг нийтлэг хууль зүйн соёл болгон нутагшуулах нь боломжгүй биш боловч олон үе дамжин шантаршгүйгээр хийгдэх ёстой хэцүү ажил юм. Мартин Кругерийнхээр, “хэцүү факт нь зайлшгүй байдлыг илтгэдэггүй. ...түүхэн хандлага, хэцүү факт ямар байхаас үл хамааран бэрхшээлтэй шилжилтийн үед хүний үйл ажиллагаа чухал нөлөөтэй гэдгийг дутуу үнэлж болохгүй.”³¹ Тиймээс, Монгол Улстай адил шилжилтийн улсад хууль дээдлэх болон үндсэн хуульд ёсыг хэрхэн бэхжүүлэх вэ гэдгийг урт хугацаанд харж тодорхой алхмыг үе шаттайгаар хийх зайлшгүй шаардлагатай.

Үндсэн хуулиар тодорхойлсон туйлын хүслэнг хэрэгжүүлэхийн тулд үндсэн хуульд ёсыг төлөвшүүлэх нь зайлшгүй юм. Үүнийг зохиогч “Ёс зарчим, үзэл баримтлалыг тунхаглах, лоозондох нь хагас алхам. Харин гүйцэд алхах буюу бодит үр дүнд хүргэхийн тулд ихээхэн хүчин чармайлт шаардана.” гэжээ.³² Үндсэн хуулийг дээдлэн шүтэх үзлийг төлөвшүүлэх хүрээнд 2006 оны байдлаар дараах ажлыг хийсэн тухай өгүүлжээ:

- Хуучин хуулиудыг үндсэнд нь шинэчилсэн;
- Нийгмийн шинэ харилцааг тусгасан хууль олныг гаргасан;
- “Өөрчлөлт, шинэчлэлт”-ийн зарим салбар үзэл баримтлал, цөөнгүй хөтөлбөр гаргасан;
- Үндсэн хуулийг 3 удаа хэвлэн нийтэлсэн;
- Судлаач багш нар зарим ном зохиол санаачлан нийтлүүлсэн;
- Хуульч бэлтгэхдээ зааж зөвлөж, судлуулж ирсэн;
- Жил бүр Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэх үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслээр ганц хоёр өдөр “сурталчилж” заримдаа хурал цуглаан зохиож дадсан;

³¹ Martin Krygier, “Institutional Optimism, Cultural Pessimism and the Rule of Law,” in *The Rule of Law After Communism: Problems and Prospects in East-Central Europe*, ed. Martin Krygier and Adam Czarnota (Ashgate Publishing, 1999), 100.

³² Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (УБ, 2006), 135.

- Төв музейд 2001 оны 1 дүгээр сард Үндсэн хуулийн булан нээж үзмэр дэлгэсэн гэх зэрэг.³³

Гэвч Үндсэн хуулийг дээдлэн шүтэх үзлийг төлөвшүүлэх ажил ахиц муутай байгааг дараах жишээ баримтаар нотолсон байна:

- ... өнгөрсөн 12 жилд Үндсэн хуулиа сурталчилж түүнд сурган хэвшүүлэх ажлыг баг хороо, айл өрх хүртэл улсын хэмжээний өргөн цартай, улирал жил дамнасан “урт” хугацаатай, шахаж шаардаж, шалгаж дүгнэдэг эзэн шалгууртай тогтмол ажил хараахан болгосонгүй алгуурлажээ гэхэд хилсдэхгүй.
- Төрийн ба нутгийн байгууллага, албан хаагчдыг Үндсэн хуулиар хангах, тэднийг энэ талаар зохих хэмжээний мэдлэгтэй болгоход тухайлж анхаарсангүй...
- Төрийн албанд хүмүүсийг шалгаруулан шилж авах, улс төрийн ажилтан бэлтгэхэд энэ асуудлыг тодорхой болзол, шалгуур болгож анхаардаггүй байна...
- Манай улс төрч болон төрийн албанд горилогч зарим хүн энгийн байхдаа Үндсэн хуулиа сайтар судлаагүй байж “зад муулчхаад”... Үндсэн хуулийн нэр барьж өргөмжлөгдөөд эрх тушаал эдэлмэгц... Үндсэн хуулиа өөрчлөх ухааны юм яриад эргээд дайрдаг.
- Цэцийн шийдвэрийг Улсын Их Хурал ойшоон үзэхгүй алгуурладаг муу зуршил сүүлийн 10 жилд мэр сэр үзэгдээд цаашдаа архагших янзтай...
- Хуулийн бус дээд сургуульд Үндсэн хуулийн сургалт үгүйлэгдэж заримд нь нэр төдий зүйл болж байгааг судалгаа харуулжээ...
- Өдгөө Соросын сангийн явуулсан бэлтгэл, туршилт хөтөлбөр хийгээд сурах бичгүүд 8-9 дүгээр ангид Үндсэн хуулийн зарим сэдвийг орж

³³ Мөн энд, 135-136.

буй нь сайшаалтай боловч эргэж харууштай
зүйл байна...³⁴

Үндсэн хуулиа нийтээрээ ойлгон ухамсарлах нь үндсэн хуульт ёсыг хэрэгжүүлэхэд чухал гэдгийг онцолж, дараах арга хэмжээг шат дараатайгаар тогтмол явуулахыг 2006 онд санал болгож байжээ:

Үндсэн хуулийн агуулга, заалт, ач холбогдол иргэд, төрийн албан хаагч, сурагч оюутан залууст тайлбарлан таниулах, сургалт явуулах агуулга бүхий “Үндсэн хуулийн албан, албан бус сургалтын хөтөлбөр”-ийг Засгийн газрын хэмжээнд төлөвлөн санхүүжүүлж тодорхой хугацааны давтамжтайгаар явуулах;

Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагыг Үндсэн хуулиар хангаж “төрийн хэрэг” хөтлөх журамд хүндэтгэлтэй, хариуцлагатай байр эзлүүлэх;

Төрийн ба нутгийн албан хаагчдын “Үндсэн хууль” сургалт семинарыг жил бүр сум, дүүргийн Засаг даргын болон яам, агентлагийн шугамаар зохион явуулж, шалгаж дүгнэж байх;

Үндсэн хуулийн өмнө андгай, тангараг өргөх ёс журмыг хянан үзэж нэр хүндийг нь дээшлүүлэхүйц хэлбэр журамд оруулах, ёс болгох хандлагаас ангижрах;

Төрийн шүтээний зан үйлийг дэмжиж зөв хэвшүүлэх (сүлд залах, төрийн туг, далбаа мандуулах тахиx, Үндсэн хуулийн өмнө тангараг, андгай өргөх, сүлд дуулал эгшиглүүлэх, УИХ-ын чуулган, нутгийн Хурлын хуралдаан эхлэхэд Үндсэн хуулийн өмнө хүндэтгэлийн ёслол үйлдэх гэх зэрэг);

Үндсэн хуулийг зөв тайлбарлах замаар Цэцийн эрх, үүргийг үндсэн хуульчилсан актаар дэлгэрүүлэн тогтоож түүний үйл ажиллагааны цар хүрээ, онолын түвшин, практик үндэслэлийг дээшлүүлэх;

Үндсэн хуулийг хүн амын янз бүрийн давхраанд зориулан уншиж судлах, залж “тахих”-д дөхөмтэй хэлбэр

³⁴ Мөн энд, 125-138.

хэмжээгээр хэвлэн нийтлэх, болж өгвөл үнэгүй түгээх (Жишээ нь: Шинээр гэрлэгчдэд зориулан баринтаглан хэвлэж гэрлэх ёслолын ордонд тавьж түгээх нь “бөгжнөөс” яахин дутах билээ. Түүнтэй зүйрлэх ч аргагүй мэт);

Ном товхимол гарын авлага боловсруулах, энэ чиглэлээр эрдэм шинжилгээний чанарлаг ажлыг хөхиүлэн дэмжих;

Аймаг, сум, багийн Засаг захиргааны газруудыг Үндсэн хуулийн мэдээллийн булан, сантай болгох, нийслэлд олон нийтэд зориулсан “Танхим” бий болгож иргэдэд үйлчлэх зэргээр уг ажлыг шинэ хөдөлгөөнд оруулж эрчимжүүлэн тогтмолжуулах;

Радио, телевизийн нэвтрүүлэгт тайлбар, үзүүлбэрээс гадна Засгийн газраас санхүүжүүлж өглөө, оройн “уншлага” оруулах зэрэг.³⁵

Үндсэн хууль дээдлэх үзэл, дадлыг суулгахад чиглэсэн эдгээр 10 арга хэмжээний дийлэнх нь 18 жилийн дараа буюу өнөөдөр ч хэрэгжээгүй байгаа нь харамсалтай. Дөрвөн арга хэмжээг нь тус илтгэлд эргэн сануулья.

Нэгд, Үндсэн хуулийг тайлбарлан таниулахад чиглэсэн албан болон албан бус сургалтын хөтөлбөрийг Засгийн газрын хэмжээнд төлөвлөн санхүүжүүлж тодорхой хугацааны давтамжтайгаар хараахан хэрэгжүүлээгүй байгааг анхаарах нь зүйтэй. Учир нь, “Үндсэн хууль дээдлэх үзэл, дадлыг нийт иргэн, төрийн албан хаагч, улс төрчид, ялангуяа залуу үеийнхэнд итгэл үнэмшил, дадал зуршил болон төлөвшүүлэхэд зориуд анхаарал тавьж төрийн бодлогын түвшинд зохих шийдвэр гарган хэрэгжүүлбэл ардчиллын үнэт зүйлүүдийг ард түмний хүртээл болгож шинэтгэлийг гүнзгийрүүлэхэд чухал тус үзүүлнэ.”³⁶

Үндсэн хуульд ардчилал нь оршин тогтноход төрийн эрх мэдэл хуваарилалт, хяналт, тэнцлийн нарийн тогтолцоо

³⁵ Мөн энд, 138-139.

³⁶ Мөн энд, 138.

шаардлагатайгаас гадна түүнийг ойлгож дэмждэг итгэл үнэмшил, соёл, хандлага нэн чухал. Ардчиллыг иргэдийн олонх дэмжиж байгаа тохиолдолд л ардчилал урт хугацаанд тогтвортой, аюулгүй хэрэгжих боломжтой. Улс төрийн философич Жон Роулс ардчилсан нийгмийн талаарх хэд хэдэн фактыг танилцуулсны нэг нь: “улс төрийн идэвхтэй иргэдийн дийлэнх нь ардчилсан дэглэмийг сайн дураараа, чөлөөтэй дэмжих ёстой; үгүй бол тухайн дэглэм тогтвортой байж чадахгүй.”³⁷ Тухайлбал, ардчилагчидгүй болбол ардчилал устдаг гэдгийг Веймарын Бүгд найрамдах улсын түүхээс харж болно:

Ваймарын Бүгд найрамдах улс бол ардчилагчидгүй ардчилал байсан. Сонгогчид нь парламентын тогтвортой олонх дээр санал нэгдэж хэзээ ч чадаагүй бөгөөд асуудал үнэхээр хэцүү болоод ирэнгүүт тэд төрийг түүний дайсны гарт өгсөн юм. Төрийн эрх мэдлийг гартаа авагсад нь Үндсэн хуулийн өөрийнх нь гол шинжүүдийг хүчингүй болгох замаар хангалттай хариу барьсан.³⁸

Тиймээс, Монгол Улсад үндсэн хуульт ардчиллын суурь зарчмуудыг ойлгох, эдгээр зарчмын дагуу улс төрийн гол асуудлуудыг шийдвэрлэх, зарим тодорхой асуудал дээр санал зөрсөн эсэхээс үл хамааран эдгээр зарчмуудыг дэмжих, хамгаалах хэмжээнд иргэдийг гэгээрүүлэхэд анхаарч, төрийн бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй.

Ардчилсан Үндсэн хууль батлагдаад 32 жил болж буй ч Үндсэн хуулиа хангалттай таниулж сурталчилж чадаагүй хэвээр байна. Үндсэн хууль, ардчилал, хүний эрхийн боловсролын агуулга тодорхой хэмжээнд Ерөнхий боловсролын сургууль (цаашид “ЕБС” гэх)-ийн Түүх, Нийгмийн тухай мэдлэг, Иргэний боловсрол зэрэг хичээлийн хөтөлбөрт тусгагдаж ирсэн боловч агуулга, арга

³⁷ John Rawls, *Justice as Fairness: A Restatement*, ed. Erin Kelly (Belknap Press, 2001), 34.

³⁸ David P. Currie, *The Constitution of the Federal Republic of Germany*, 1st ed. (University of Chicago Press, 1995), 7.

зүйн хувьд учир дутагдалтай. Жишээлбэл, Иргэний боловсрол, Иргэний ёс зүйн боловсрол хичээлүүдийн сурах бичгийн хүрээнд хийгдсэн хэд хэдэн судалгаанд “уг хичээлийн агуулгыг харвал ардчиллын үнэт зүйл, зарчмын талаарх агуулга дутмаг,”³⁹ “иргэний ёс зүйн боловсрол сурах бичиг нь ёс суртахууны философийн өнөөгийн түвшинд нийцэхгүй төдийгүй ардчилсан улсын улс төрийн үнэт зүйл эзэмшүүлэхэд чиглэсэн агуулга хангалтгүй”⁴⁰ гэж дүгнэжээ. Энэ хичээлийн сурах бичигт “хүний эрхэм чанар, хүний эрх, эрх чөлөө, ардчилал, тэгш байдал, хууль дээдлэх ёс зэрэг боловсролын сууринд байх ёстой эрхэмнэлүүдтэй холбох, агуулгад тусгах шаардлагатай.”⁴¹ Сурагчид либерал ардчилалд суралцах, түүний суурь зарчим, үнэт зүйлийн дагуу орчин үеийн улс төрийн асуудлыг хэлэлцэж дүгнэлт өгөх, үндэслэл бүхий шийдвэр гаргах чадвараа хөгжүүлэх боломж албан боловсролын тогтолцоонд хязгаарлагдмал байгааг хичээлийн хөтөлбөр, агуулгаас харж болно.

Төрийн болон бусад байгууллага, хувь хүн иргэний боловсролыг дэмжих чиглэлд албан бусаар олон арга хэмжээ авч хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, иргэний боловсролын хөтөлбөрийг сайжруулах, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, ЕБС, их дээд сургуулийн багш нарын иргэний боловсролын мэдлэг, арга зүйг дээшлүүлэх чиглэлээр “Иргэний боловсрол төв” ТББ 30 шахам жил ажиллаж байна.⁴² “Нээлттэй нийгэм форум” ТББ ч энэ чиглэлд 20 гаран жил хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн.⁴³ Мөн, сүүлийн жилүүдэд УИХ-ын Тамгын газар “Парламентын боловсрол” төсөл хэрэгжүүлж энэ чиглэлийн видео, гарын авлага, сургалтын

³⁹ О.Мөнхсайхан, Р.Очирбал, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл (тойм судалгаа) (УБ, 2021), 138-139.

⁴⁰ С.Төмөр-Очир, Б.Жадамба, Ц.Өнөрбаян, Ч.Ганзориг, С.Цогбадрах, Монгол Улс: эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл (Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичигт хийсэн шинжилгээний дүнгийн тайлан) (УБ, 2021 оны 11 сар), 76.

⁴¹ М.Отгонбаяр, Б.Дагзмаа, “Иргэний ёс зүйн боловсрол сургалтын хөтөлбөр, агуулгад хийсэн шүүмжлэлт зарим эргэцүүлэл” (УБ, 2022), 2.

⁴² Иргэний боловсрол төв, <http://www.cce.mn/>

⁴³ Нээлттэй нийгэм форум, <https://forum.mn>

хөтөлбөр гарган түгээж байна.⁴⁴ Олон төрлийн ном, сурах бичиг, гарын авлага сайн дураар хэвлэгджээ.⁴⁵ Түүнчлэн, 2022 онд МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн Үндсэн хуулийн мэдлэг, хүний эрхийн боловсрол олгох зорилготой “Үндсэн хууль манай сургуульд” төсөл хэрэгжүүлж, 8 сэдвээр сургалтын хөтөлбөр, материал боловсруулж, ахлах ангийн сурагчид, оюутнууд болон иргэдэд сургалт орж байна.⁴⁶ Харамсалтай нь, ардчиллын боловсролын энэ бүх санаачилга ЕБС-ийн албан ёсны хөтөлбөр, сурах бичиг, багшлах боловсон хүчний бодлого руу хангалттай хүрч, бүрэн тусаж чадалгүй өдий хүрчээ.

Хоёрт, зохиогч Үндсэн хуулийг мушгин гуйвуулах, эсхүл андуурч тайлбарлах тохиолдлыг хүлцэн тэвчихгүй байхыг анхааруулсан. Тодруулбал, “Шинжлэх ухааны нэр барьж Үндсэн хуулийг мушгин гуйвуулах хандлагаар түүний зарим заалт, үндэслэлийг бүдүүлгээр дайрч үгүйсгэх явдал мэр сэр үзэгддэгийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлж буй илрэл хэмээн хүндэтгэн үзэж болох хэдий ч төрийн эрх зүйн онолын үүднээс хүлээн зөвшөөрсөн мэт хүлцэнгүй суух боломжгүй.”⁴⁷ Ийм гуйвуулгын жишээ болсон нэгэн бүтээлийг⁴⁸ шинжлэхэд “түүнийг зохиогч нь эхлээд Үндсэн хуулийг (төрийн хэлбэрийн хувьд ерөнхийлөгчийн засаг тогтох, нам нь УИХ-ыг тараах, гишүүнийг эгүүлэн татах, гишүүн нь императив мандаттай байх гэх зэргээр хуучин зарчмыг эргүүлэн) өөрчлөх тухай хувийнхаа бодол санааг дугаарлан жагсаагаад түүнийгээ “нотлох”-ын тулд элдэв хоёроор хэлжээ.”⁴⁹ Мөн, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 1.2-т “Багшлах эрх чөлөө нь Үндсэн хуульд үнэнч байхаас чөлөөлөгдөхгүй” гэж заасныг эшилж, тус улсын туршлагад

⁴⁴ Монгол Улсын Их Хурал, “Парламентын боловсрол,” <https://www.parliament.mn/nc/516/?page=2>

⁴⁵ “Ардчиллын үнэт зүйлс” сургалтын хураангуй хөтөлбөр (Хүүхдийг ивээх сан); “Ардчиллын үнэт зүйлс” сургалтын дэлгэрэнгүй хөтөлбөр (Хүүхдийг ивээх сан).

⁴⁶ МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Үндсэн хууль манай сургуульд: НҮБ-ын Хүний эрхийн гэрээний хорооны Ерөнхий тайлбар болон сургалтын хөтөлбөр (2022)

⁴⁷ Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (УБ, 2006), 141.

⁴⁸ Монгол Улсын төрийн байгууллагуудын чадавхи: Ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэх шаардлага боломж (УБ, 1998)

⁴⁹ Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (УБ, 2006), 141-142.

тулгуурлан Үндсэн хуулийн байгууллын үндэс болсон Үндсэн хуулийг гуйвуулсан дуу хоолой их сургуулийн хананаас гарах ёсгүй гэдгийг сануулсан.⁵⁰ Түүнчлэн, энгийн зарим өгүүлэл, мэдээнд Үндсэн хуулийн үзэл баримтлалыг андуурч тайлбарласан жишээг ч дурдаад энэ мэт нь “Үндсэн хуулийн эрх зүйн талаарх хувь хүний ухамсрын түвшинтэй холбоотой байхаа” гэжээ.⁵¹

Шинжлэх ухааны нэр барьж эсхүл ердийн ухамсрын түвшинд ардчилсан Үндсэн хуулийг мушгин гуйвуулах тохиолдол 2006 оноос хойш ч гарсаар байна.⁵² Ийм өнгөц үзлийг ултай судалгаа, үндэслэлтэйгээр няцаах, үндсэн хуульт ардчиллаа хамгаалах нь иргэний, ялангуяа сэхээтэн (эрдэмтэн, судлаач, хуульч, багш, оюутан зэрэг)-ий эрхэм үүрэг юм. Үндсэн хуульт ардчилал нь түүний суурь зарчим, үнэт зүйлийг дэмжиж хамгаалдаг сэхээтнүүдгүйгээр бэхжиж чадахгүй. Роулсынхаар, “Веймарын Үндсэн хууль яагаад бүтэлгүйтсэн олон шалтгааны нэг нь тухайн үеийн Германы шилдэг философичид зэрэг оюунлаг хэсгийн нэг нь ч түүнийг хамгаалах хүсэлгүй байсан явдал юм.”⁵³ Тиймээс, либерал ардчиллын үнэт зүйлийг олон нийтэд таниулах, энэ чиглэлд сайн бүтээл туурвих, сор болсон бүтээл, эх сурвалжийг орчуулах, диалог, шүүмж өрнүүлэх зэрэг үүргийг сэхээтнүүд гүйцэтгэх нь үндсэн хуульт ардчилал төлөвшихөд амин чухал билээ.

Гуравт, БНМАУ-ын Ардын Их Хурал 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийг баталж, Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх замаар түүнийг чандлан сахиулах чиг үүрэг бүхий Үндсэн хуулийн шүүхийг

⁵⁰ Мөн энд, 140.

⁵¹ Мөн энд, 142.

⁵² Жишээлбэл, ерөнхийлөгчийн засаг хоёр танхим руу шилжих талаар зарим ном гарч, шинэ Үндсэн хуулийн төсөл ч хүртэл хэвлүүлсэн байна. Д.Зоригтбаатар, Р.Ууганбаяр, Д.Лхагвасүрэн, М.Сайнбаяр, Д.Сүхболд, Бүгд Найрамдах Монгол Ард Улс: Үндсэн хуулийн тайлбар философи (УБ, 2020); БНМАУ-ын Үндсэн хуулийн төсөл (УБ, 2020); Бүгд Найрамдах Монгол Улсын Үндсэн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (2022); Л.Мөнх-Эрдэнэ, Монголын намын улс: зөвлөлийн, намын олигарх засаглал (УБ, 2022).

⁵³ John Rawls, Lectures on the History of Political Philosophy (Belknap Press of Harvard University Press, 2008), 6.

анх удаа бий болгож, Үндсэн хуулийн цэц гэсэн оноосон нэр өгсөн. Монгол Улсын Бага Хурал 1992 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг баталж Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуульчилсан бол 1992 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа Үндсэн хуулийн цэцийн анхны бүрэлдэхүүнийг томилжээ. Улмаар УИХ 1997 оны 5 дугаар сарын 01-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг баталж маргаан хянан шийдвэрлэх журмыг тусгайлан зохицуулжээ.

“Үндсэн хуулийг зөв тайлбарлах замаар Цэцийн эрх, үүргийг үндсэн хуульчилсан актаар дэлгэрүүлэн тогтоож түүний үйл ажиллагааны цар хүрээ, онолын түвшин, практик үндэслэлийг дээшлүүлэх” саналыг зохиогч дэвшүүлж байсан ч өнөөдрийг хүртэл биеллээ олоогүй байна. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль тогтоомжийг анхлан баталснаас хойших хугацаанд эдгээр хуульд зарчмын гэх дорвитой өөрчлөлт хийгдээгүй явж ирсэн хэвээр байна. Өнгөрсөн 32 жилийн хугацаанд Монгол Улсын төр, нийгэм, эдийн засгийн харилцаанд гарч буй шинэчлэл, хөгжлийн хурдац, нийгмийн шаардлагын үүднээс шүүх эрх мэдлийн бусад байгууллагын нэгэн адил Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг шинэчлэн боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигддаг. Энэ хүрээнд 2015, 2024 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хууль санаачлагчдаас УИХ-д өргөн мэдүүлсэн боловч хэлэлцэн батлагдаагүй байхад байна.

Дөрөвт, 1999, 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд шүүмжлэлтэй ханджээ. Процедур талаасаа “Үдийн завсарлагыг эс тооцвол 2-3-хан цагт “маналзуулсан” нэргүй актыг сар, жилээр боловсруулж 6 сар дамжуулан хэлэлцэж, баталсны хойно 1 сарын дараа хүчин төгөлдөр болгон мөрдсөн

Үндсэн хуультай адилтгана гэдэг арай дэндсэн шалтаг...” гэх зэргээр дүгнэсэн байна. Агуулга талаасаа “парламент, Засгийн газар хоёрын бүрэлдэхүүнийг “үнээ тугал нийлүүлсний” адил хольж хутгасан нь цөөн гишүүнтэй парламент, харьцангуй олон гишүүнтэй Засгийн газар хоёрын харилцан хяналт тавьж, сөрөн зогсож, тэнцвэржих зарчимд үнэхээр харшилжээ.” гэх зэргээр тухайн нэмэлт, өөрчлөлтийн заалт бүрийг дүгнэж бичжээ.⁵⁴ Үндсэн хуулиар нийгмийн бүхий л харилцааг зохицуулах боломжгүй учир нарийвчилсан асуудлыг органик болон ердийн хуулиар зохицуулснаар Үндсэн хууль өөрөө амьдралд бууж, хэрэгжих тул Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь тэдгээр хуулиар зохицуулаад ч үр дүнд хүрэхгүй болсон тохиолдолд эцсийн сонголт байх учиртай гэжээ. Өөрөөр хэлбэл, “... улс төрийн аль нэг нам, бүлгийн явцуу сонирхол, албан тушаалын төлөөх шохоорхолд автахгүйгээр онол-мэргэжлийн өндөр түвшинд боловсруулсан, ард түмний олонхын санаа бодол, олон намын зүй ёсны нийтлэг сонирхолд буюу ашиг сонирхлын огтлолцолд тохирсон зайлшгүй тодруулалт хийж болох” бөгөөд “эцсийн дүнд дордуулсан биш, сайжруулсан л байх ёстой.”⁵⁵

1992 оны Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь улс төрийн явцуу сонирхлыг хангах бус, харин үндсэн хуульд ардчиллыг бэхжүүлэх зорилготой байх бөгөөд тухайн Үндсэн хуультайгаа адил хүлээн зөвшөөрөгдөж, легитим шинжийг олж авах шаардлагатай. Процедур талаасаа, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хангалттай хугацаанд судалгаанд тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд боловсруулж, иргэдийг өргөнөөр оролцуулж, улс төрийн зөвшилцлийг хангаж, нээлттэй, чөлөөтэй хэлэлцүүлж, УИХ дээр гурваас доошгүй хэлэлцүүлэг хийж, өндөр босго (дөрөвний гурвын санал)-оор холбогдох хуулийг⁵⁶ чанд баримталж батлах,

⁵⁴ Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (УБ, 2006), 143-147.

⁵⁵ Мөн тэнд, 143.

⁵⁶ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай, Хууль тогтоомжийн тухай, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай зэрэг хуулийг баримтлах нь зүйтэй.

үүний үр дүнд тухайн нэмэлт, өөрчлөлтийг дэмжсэн уур амьсгал бүрдсэн байх нь түүний хүлээн зөвшөөрөгдөх байдал, легитим шинжийг хангана.⁵⁷ Агуулга талаасаа, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцсэн байвал зохино. Өөрөөр хэлбэл, уул нэмэлт, өөрчлөлт нь парламентын засгийг үгүйсгэж, төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг сулруулж, үндсэн эрхийг дордуулж болохгүй. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд агуулгын болон процедурын эдгээр шаардлагыг хангах хэрэгтэй ч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад аливаа хязгаарлалт тогтоохгүйгээр олон дахин өөрчилбөөс Үндсэн хуулийн тогтвортой шинж алдагдаж, улмаар Үндсэн хуулиар тогтоосон үнэт зүйл хэрэгжих боломжгүй болохыг үндсэн хуульд ёстой холбон зохиогч тайлбарласныг санахад илүүдэхгүй юм.

V. Дүгнэлт

Монголчуудын төрт ёс, хууль зүйг дээдлэн шүтэх үзэл гурван их үеийг туулж ирсэн болохыг зохиогч номын энэ бүлгээр танилцуулж, 1992 онд анхны ардчилсан Үндсэн хуулиа баталснаар хууль дээдлэх ёс (эрх зүйт төр) төлөвшиж эхэлснийг онцолжээ. 1992 оны Үндсэн хуулийг боловсруулж, хэлэлцэж батлахдаа олон нийтийн оролцоо, улс төрийн зөвшилцлийн үндсэн дээр ард түмний бүрэн эрхт байдлыг хангасны зэрэгцээ түүний оршилд “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх” хэмээн ард түмний туйлын хүслэнг тодорхойлж ардчилсан Үндсэн хуулийн агуулгыг бүрэн тусгасан нь уг Үндсэн хуулийг дээдлэн шүтэх (хүндэтгэх) үндэслэл болжээ. 1992 оны Үндсэн хууль нь парламентын засгийг тогтоож, нийгэм, эдийн засаг, улс төр, социал хүрээнд олон янзын шинэчлэл хийгдэх суурь болжээ. Үндсэн хууль тогтвортой байж, түүнийг танин мэдэж, тууштай сахин биелүүлснээр түүнд заасан үндсэн эрхийг баталгаатай

⁵⁷ О.Мөнхсайхан, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт: өгүүлэл, илтгэл, санал, III боть (УБ, 2023), 3-32.

эдэлж, төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцэл бодитой хангагдана.

Б.Чимид багш номынхоо төгсгөлд “Хууль дээдлэх ёсон бол засаг төр барих урлаг, хүн зон амар жимэр амьдрахуйн арга юм... төр барьж, түмэнд үйлчлэх урлагт суралцахад Үндсэн хууль судал, тэр дундаа түүхэн хийгээд харьцуулсан судлалыг хөгжүүлэн түшиглэх шаардлага өссөөр буйг харгалзан нэгийг бодох цаг болжээ” гэдгийг захиж үлдээжээ. Иймд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй бүхий л түвшинд болон иргэдийн зүгээс Үндсэн хуулийг танин мэдэж, судалж байх нь түүний агуулга, ач холбогдлыг ойлгож дээдлэн шүтэх (хүндэтгэх), хэрэгжүүлэх, улмаар Үндсэн хуульт ардчилсан улсын өнө удаан оршин тогтнох үндэс болно.